



НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

**БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ТЭТГЭЛЭГТ
ХӨТӨЛБӨР**

**СЭТГЭЦИЙН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ
ХҮҮХДҮҮДИЙН СУУРЬ БОЛОВСРОЛ
ЭЗЭМШИХ БОЛОМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ**

Гүйцэтгэгч: Л. ЗОЛБААТАР
Нээлттэй Нийгэм Форумын
бодлогын судлаач

Улаанбаатар хот
2006 он

DDC
371.94
C-976

НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

Хаяг: Жамъян гүний гудамж-5/1,
Сүхбаатар дүүрэг

Утас: 976-11-313207

Факс: 976-11-324857

Вэб хуудас: <http://www.forum.mn>

И-мэйл: osf@soros.mn

*Уг судалгаагаар гаргасан дүгнэлт, саналууд нь
судлаачийн байр суурь, үзэл бодлыг илэрхийлнэ.*

© Энэхүү номыг хэсэгчлэн болон бүтнээр нь дахин хэвлэхийг хүсвэл ННФ-ын хаягаар хандаж зохих зөвшөөрөл авна уу.

*Тайланг сонирхсон байгууллага, хувь хүмүүст
хямдралтай үнээр зарна.*

ISBN 978-99929-54-05-1

“СОДПРЕСС” ХХК-д эхийг бэлтгэж хэвлэв.

ГАРЧИГ

ЗУРАГ, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	5
ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	6
ХУРААНГУЙ	7
СУДАЛГААНЫ ЗОРИЛГО	11
СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ	12
- Баримт бичгийн судалгаа	12
- Хээрийн судалгаа	12
- Мэдээлэл боловсруулалт	14
- Судалгааны хязгаарлагдмал байдал	14
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДҮҮД БОЛОН ТЭДНИЙ БОЛОВСРОЛ ЭЗЭМШИЖ БУЙ ТАЛААРХ ТООН МЭДЭЭЛЭЛ	15
СЭТГЭЦИЙН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДҮҮДИЙН БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХ АСУУДЛЫН ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭ	18
- Олон улсын баримт бичгүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх тусгагдсан нь	18
- Монгол улсын хууль эрх зүйн актуудад сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсрол эзэмших талаар тусгагдсан байдал	19
СЭТГЭЦИЙН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХЭД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛС	23
- Хөгжлийн бэрхшээлийн тодорхойлолт, ашиглаж буй аргачлалаас үүдэлтэй хязгаарлалт	23
- Боловсролын тогтолцоотой холбогдолтой хүчин зүйлс	25
- Эцэг эхээс шалтгаалах хүчин зүйлс	30
- Эрүүл мэндийн тогтолцооноос хамаарах хүчин зүйлс	31
- Нийгмийн хамгааллын тогтолцооноос хамаарах хүчин зүйлс	33
ДҮГНЭЛТ	34
ЗӨВЛӨМЖ	36
ЭХ СУРВАЛЖУУД	41



ТАЛАРХАЛ

Энэхүү судалгааг гүйцэтгэхэд тусламж, дэмжлэг үзүүлсэн судалгаанд хамрагдсан хүүхдүүд, тэдний эцэг эх, хороо сумдын Засаг дарга болон түүний Тамгын газрын ажилтан, эмч, эмнэлгийн ажилтан нарт гүн талархал илэрхийлж байна.



ЗУРАГ, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Зураг 1: Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн боловсрол эзэмшиж буй байдал	26
Зураг 2: Судалгаанд хамрагдсан ердийн сургалттай ЕБС-д сурч байгаад сургууль завсардсан хүүхдийн завсардсан шалтгаан	27
Зураг 3 Судалгаанд хамрагдсан хүүхдийн боловсрол эзэмшиж буй байдал (эцэг/эхийн боловсролын түвшин/хүүхэд боловсролын үйлчилгээнд хамрагдсан байдалтай харьцуулахад)	31
Зураг 4: Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн оношлогоо хийлгэсэн эмнэлэг	32
Хүснэгт 1: Судалгаанд хамрагдсан сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эх/асран хамгаалагч оршин сууж буй аймаг/хотоор)	13
Хүснэгт 2: 0-15 настай сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тоо, бэрхшээлийн хэлбэрээр	16
Хүснэгт 3: 15, түүнээс дээш настай сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бичиг үсгийн мэдлэг, боловсролын түвшин (бэрхшээлийн хэлбэрээр)	16
Хүснэгт 4: 7-29 насны сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сургуульд суралцагсдын тоо, сургуульд хамрагдалтын хувь (бэрхшээлийн хэлбэр, хүйсээр)	17

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
БСШУЯ	Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам
НХХЯ	Нийгмийн Хамгаалал Хөдөлмөрийн Яам
УИХ	Улсын Их Хурал
ҮСГ	Үндэсний статистикийн газар
ЭМЯ	Эрүүл Мэндийн Яам
ЭНЭШТ	Эх нялхсын эрдэм шинжилгээний төв

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн: «Төрөлхийн болон удамшлын эмгэг өөрчлөлт, эсхүл осол, гэмтлийн улмаас сэтгэц, оюун ухаан, мэдрэхүйн чадавхи нь алдагдсан, түүнчлэн бие эрхтэн нь гэмтсэнээс хөдөлмөрлөх, бие даан амьдрах боломж нь хязгаарлагдсан хүнийг «хөгжлийн бэрхшээлтэй иргэн» гэж ойлгоно¹».

«Суурь боловсрол» гэж 9 жилийн сургалтын агуулгын түвшинг ойлгоно²».

Тусгай хэрэгцээт боловсрол: «Оюун ухааны хөгжил дутуу, хэл, хараа, сонсголын эрхтний согогтой хүүхдэд олгох боловсролыг тусгай хэрэгцээт боловсрол гэнэ³» .

¹ УИХ, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль”, 2005 оны 12-р сарын 8 өдөр

² УИХ, “Боловсролын тухай хууль”, 2002 оны 5-р сарын 3 өдөр

³ УИХ, “Бага, дунд боловсролын тухай хууль”, 2002 оны 5-р сарын 3 өдөр

ХУРААНГУЙ

«Монгол Улсын иргэн сурч боловсрох эрхтэй» Монгол Улсын Үндсэн хууль

Сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн суурь боловсрол эзэмших боломж одоогийн эрх зүйн орчны болон нийгмийн хандлагын хүрээнд хязгаарлагдмал байгаа нь бодит байдал юм. Энэхүү судалгааны үндсэн зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсрол эзэмшихэд тулгарч буй хүндрэл бэрхшээлийг тодруулан тухайн асуудлыг шийдвэрлэх арга зам, аргачлал, сонголтыг бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгч нарт санал болгон дэвшүүлэхэд оршсон билээ.

«Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль» нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тодорхойлох, нийгмийн хамгааллын тогтолцооны хүрээнд тухайн иргэнд хүргэх үйлчилгээ, тусламж, хөнгөлөлтийн цар хүрээ, хэмжээг тодорхойлсон үндсэн эрх зүйн зохицуулалт болдог⁴.

«Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль»-д аймаг, дүүргийн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс иргэний хөгжлийн бэрхшээлийг тодруулна гэж тодорхой заасан⁵ боловч «Нийгмийн даатгалын тухай

⁴ “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль”-ийн гуравдугаарт: “Төрөлхийн болон удамшлын эмгэг өөрчлөлт, эсхүл осол, гэмтлийн улмаас сэтгэц, оюун ухаан, мэдрэхүйн чадавхи нь алдагдсан, түүнчлэн бие эрхтэн нь гэмтсэнээс хөдөлмөрлөх, бие даан амьдрах боломж нь хязгаарлагдсан хүнийг “хөгжлийн бэрхшээлтэй иргэн” гэж ойлгоно”.

⁵ “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль”-ийн аравдугаар зүйлийн нэгд: “Иргэн хөгжлийн бэрхшээлтэй болохыг нь түүний оршин суугаа аймаг, дүүргийн эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комисс тогтооно” .

хууль»-ийн дагуу үйл ажиллагаагаа явуулж буй аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс нь нийгмийн даатгал төлөгч иргэдийн (16 нас хүрээгүй иргэн нийгмийн даатгалын төлөгч байх боломж нь хязгаарлагдмал) хөгжлийн бэрхшээлтэй эсэх, хөдөлмөрийн чадвар алдалтын хувийг тогтоодог байна.

16 нас хүрээгүй иргэдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийн талаар хүүхдийн оршин суугаа аймаг, дүүргийн Эрүүл мэндийн нэгдэл/Эрүүл мэндийн төвийн Эмчилгээний чанарын хяналтын комисс шийдвэр гаргадаг боловч тус Эмчилгээний чанарын хяналтын комиссын гаргасан хөгжлийн бэрхшээлтэй эсэх талаарх шийдвэр нь «Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль»-ийн дагуу хийгдээгүй тул эрх зүйн чадамжгүй байх эрсдэлтэй байна.

Энэхүү эрх зүйн орчны дотоод зөрчилдөөнийг дараах байдлаар шийдвэрлэж болох юм:

- Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагаанд өөрчлөлт оруулан Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс нь хүүхдийн бэрхшээлийн хэлбэр, боловсрол эзэмших чадвар алдалтын түвшин, тухайн хүүхдийн боловсрол эзэмших сургуулийн хэлбэр зэргийн талаар шийдвэр гаргадаг болох;
- Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн дэргэд «Эмнэлэг боловсролын магадлах комисс»-ыг Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын жишгээр шинээр байгуулах. Тус комисс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бэрхшээлийн хэлбэр, боловсрол эзэмших чадвар алдалтын түвшин, тухайн хүүхдийн боловсрол эзэмших сургуулийн хэлбэр зэргийн талаар шийдвэр гаргадаг болох.

Хөдөө орон нутагт сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулагдсан тусгай сургалттай ЕБС, ердийн сургалттай ЕБС-д тусгай сургалттай анги, сургуулийн

өмнөх боловсрол олгох тусгай сургалттай цэцэрлэг зэрэг боловсролын байгууллагууд байдаггүй, гэрээр боловсрол олгох тогтолцоо хөгжөөгүй нь тусгай сургалттай сургуульд суралцах зайлшгүй шаардлагатай (хүүхдийн бэрхшээл нь тухайн хүүхэд ердийн сургалттай ЕБС-д суралцах боломжийг хязгаарласан нөхцөлд) хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсрол эзэмших, нийгэмших боломжийг хязгаарлаж буй гол хүчин зүйлийн нэг болж байна.

Эрх бүхий байгууллагын (Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс/Эмнэлэг боловсролын магадлах комисс) тогтоосноор суурь боловсрол тусгай сургалттай ЕБС-д эзэмших боломжтой хүүхдүүдийг аймгийн төвүүдэд ердийн сургалттай ЕБС-д сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан тусгай анги нээн сургуульд хамруулах боломжтой тул тус асуудлыг цогц байдлаар (сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллах багш бэлтгэх, хүүхдийн хувьсах зардлыг нэмэгдүүлэх, хүүхдийн сургалтын амжилтын үнэлгээний тогтолцоонд өөрчлөлт оруулах) шийдвэрлэхэд онцгой анхаарах нь зүйтэй болно.

Ердийн болон тусгай сургалттай ЕБС-д суралцах боломжгүй хүүхдүүдэд боловсрол тодорхой хэмжээнд эзэмших, нийгэмшихэд тэдний эцэг эх, оршин сууж буй орон нутгийн ЕБС-ийн багш нарыг оролцуулан гэрээр боловсрол эзэмших тогтолцоог бүрдүүлэх нь тус хүүхдүүдийн нийгэмшихэд суурь болох тул гэрээр боловсрол эзэмшүүлэх асуудлыг мөн цогцоор шийдвэрлэх шаардлагатай.

Эцэг эхийн хүүхдийнхээ боловсрол эзэмшихэд хандаж буй хандлага, идэвх зүтгэл нь хүүхдийн боловсрол эзэмшиж буй байдал, эзэмшиж буй боловсролын чанарт шууд нөлөөлж байгаа тул эцэг эхийн хүүхдийнхээ боловсролд хандах хандлагад өөрчлөлт оруулах, хүүхдийн боловсрол эзэмших боломжийн талаарх тэдний мэдлэгийг дээшлүүлэхэд төрийн зүгээс онцгой анхаарал тавих шаардлагатай. Үүнд:

- Сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд бусдын адил боловсрол эзэмших, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох бүрэн эрхтэй гэдгийг эцэг эх, олон нийтэд сурталчлан тэдний хандлагад өөрчлөлт оруулах;

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эх, асран хамгаалагч нарт төрөөс үзүүлж буй халамжийн, эрүүл мэндийн, боловсролын үйлчилгээний цар хүрээ, үйлчилгээ авах нөхцөл, үйлчилгээ авах боломжийн талаар мэдээллийг цогц байдлаар төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоотойгоор хүргэх.

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Энэхүү судалгааны үндсэн зорилго нь сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн суурь боловсрол эзэмших боломжийг нэмэгдүүлэх арга зам, аргачлалыг боловсруулан боловсрол, нийгмийн халамжийн чиглэлийн бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгч нарт асуудлуудыг шийдвэрлэх талаар бодлогын зөвлөмж, санал боловсруулахад оршино.

Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн:

- Салбар хоорондын зааг дээр буй асуудлыг зохицуулсан хууль эрх зүйн орчинг судалж, дүн шинжилгээ хийх;
- Сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд болон тэдний эцэг эхээс нөхцөл байдлын талаар мэдээлэл цуглуулах;
- Гадаад орнуудын туршлагыг судлах;
- Бодлогын зөвлөмж боловсруулах.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

БАРИМТ БИЧГИЙН СУДАЛГАА

Суурь мэдээлэл болох хууль эрх зүйн акт, сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролын чиглэлээр өмнө хийгдсэн судалгааны үр дүнг нэгтгэх байдлаар баримтын судалгааг гүйцэтгэсэн. Баримтын судалгаа нь дараах хүрээтэй байв:

- Холбогдох хууль эрх зүйн;
- Урьд өмнө хийгдсэн судалгаа, дүн шинжилгээний тайлан, илтгэл;
- Бусад орнуудын эрх зүйн зохицуулалт, туршлага.

ХЭЭРИЙН СУДАЛГАА

Шуурхай дүн шинжилгээгээр⁶ хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, тэдний эцэг эх/асран хамгаалагчдыг хамруулан санал асуулгын асуумж⁷, ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагаар хүүхдүүдийн боловсрол эзэмшиж буй байдал, түүнд нөлөөлж буй хүчин зүйлс, эрүүл мэндийн, нийгмийн халамжийн үйлчилгээний талаар судалгааны тайлан боловсруулахад шаардагдах тоон болон чанарын мэдээллийг цуглуулсан.

⁶ Rapid assessment

⁷ Сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эх/асран хамгаалагчаас мэдээлэл цуглуулсан асуумжийн загварыг Хавсралт # 1-д үзүүлэв.

Энэхүү судалгааны хээрийн мэдээлэл цуглуулалт 2005 оны 6-10-р саруудад гүйцэтгэгдсэн бөгөөд хээрийн судалгааг сургалтанд хамрагдсан судалгааны туслахууд⁸ Улаанбаатар хот болон судалгаанд хамрагдсан аймгийн төв, сумдаас цуглуулсан. Энэхүү судалгаанд нийт 155 хүүхдийн эцэг эх/асран хамгаалагч нар хамрагдсан.

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эх/асран хамгаалагч (оршин сууж буй аймаг/хотоор)

Аймаг/хот	Давтамж	Дүнд эзлэх хувь
Архангай	14	9,0
Булган	20	12,9
Хөвсгөл	16	10,3
Хэнтий	10	6,5
Өвөрхангай	6	3,9
Сэлэнгэ	9	5,8
Орхон	26	16,8
Дорноговь	6	3,9
Улаанбаатар	48	31,0
Нийт	155	100,0

Судалгаанд хамрагдсан Улаанбаатар хот⁹, аймгийн төв, сумдын ЕБС-ийн удирдлага, багш, нийгмийн ажилтан, аймгийн Нэгдсэн эмнэлэг/дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн, өрхийн/сумын эмнэлгийн эмч, сум/хороодын Засаг дарга болон Засаг даргын Тамгын газрын түшмэлүүдээс тухайн орон нутагт оршин суудаг сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн талаарх мэдээлэлийг цуглуулсан.

Судалгаанд хамрагдсан хот, аймаг, сумдын төвд оршин суудаг насанд хүрсэн иргэдээс сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд боловсрол эзэмших талаарх олон нийтийн хандлагыг тодруулах зорилгоор асуумжийн аргачлалаар нийт 450 иргэдээс тоон мэдээлэл цуглуулсан.

⁸ Ж.Энхтуяа, Б.Амарсайхан, Ц.Ариунтуяа

⁹ Улаанбаатар хотод байрлах сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулагдсан тусгай сургалттай ЕБС-иуд, ердийн сургалттай зургаан ЕБС-ийн багш, сурган хүмүүжүүлэгч нар тус судалгааны мэдээлэл цуглуулах явцад өөрийн санал бодол, байр сууриа илэрхийлсэн.

МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАЛТ

Судалгааны явцад цуглуулсан тоон мэдээллийг SPSS программ хангамжийг ашиглан боловсруулж судалгааны тайлан бичихэд ашигласан болно¹⁰.

СУДАЛГААНЫ ХЯЗГААРЛАГДМАЛ БАЙДАЛ

Сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн суурь боловсрол эзэмших нөхцөл боломжийг судлах, хүүхдүүдийн боловсрол эзэмшихэд тулгарч буй хүндрэл, бэрхшээлүүдийг тодруулах, түүнийг шийдвэрлэх бодлогын санал дэвшүүлэхэд дараах хүчин зүйлүүд нөлөөлж байсан нь энэхүү судалгааны үр дүнг хязгаарлахад тодорхой хэмжээгээр нөлөөлсөн.

Үүнд:

- Судалгааны түүвэрлэлтийг шуурхай дүн шинжилгээний аргачлалаар хэрэгжүүлсэн нь судалгааны төлөөлөх чадварыг тодорхой хэмжээнд хязгаарлах боломжтой;
- Судалгаанд хөдөө оршин сууж буй малчдын хүүхдүүд хамрагдаж чадаагүй;
- Судалгаанд Баруун бүсийн аймгууд хамрагдаагүй.

¹⁰ Судалгааны явцад цуглуулсан тоон мэдээллийг SPSS программ хангамжийг ашиглан боловсруулсан тоон мэдээллийг энэхүү тайлангийн тоон хувилбарт хавсаргав.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДҮҮД БОЛОН ТЭДНИЙ БОЛОВСРОЛ ЭЗЭМШИЖ БУЙ ТАЛААРХ ТООН МЭДЭЭЛЭЛ

НХХЯ, БСШУЯ, ЭМЯ-ын, ҮСГ-ын хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тухайлбал сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн талаарх тоон мэдээлэл зөрүүтэй байдаг. Хүүхдүүдийн талаарх тоон мэдээлэл зөрүүтэй байгаад чиглэлийн яамд өөр өөр аргачлалыг ашиглан хүүхдийн бэрхшээлтэй эсэхийг тодорхойлж байгаа явдал юм.

Азийн хөгжлийн банкны техникийн тусламжтайгаар ҮСГ-ын хэрэгжүүлж буй «Нийгмийн статистикийг боловсронгуй болгох» төслийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх статистикийн мэдээллийг сайжруулах, бүртгэлийн аргачлалыг олон улсын жишигт нийцүүлэх зорилгоор 2004 онд гүйцэтгэсэн «Тахир дутуу иргэдийн нэг удаагийн бүртгэл» нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх тоон мэдээллийг харьцангуй цогц байдлаар цуглуулсан.

Дээрх бүртгэлээр 2004 оны 5-р сарын 24-ний байдлаар Монгол Улсад нийт 69263 хөгжлийн бэрхшээлтэй иргэн оршин сууж байсан бөгөөд тэдний 1868 нь 0-15 настай сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд байв.

Хүснэгт 2. 0-15 настай сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тоо, бэрхшээлийн хэлбэрээр¹¹

Бэрхшээлийн хэлбэр	0-15 насны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо
Хүнд сэтгэцийн эмгэг	143
Хөнгөн сэтгэцийн эмгэг	132
Оюуны хомсдол-хүнд	575
Оюуны хомсдол-хөнгөн	427
Тархины гэмтэл-хүнд	377
Тархины гэмтэл-хөнгөн	214
Нийт	1868

Тус бүртгэлээр мөн бүртгэлд хамрагдсан иргэдийн бичиг үсэг тайлсан байдал, боловсролын түвшин, боловсрол эзэмшиж буй байдлыг тодорхойлсон байна.

Хүснэгт 3. 15, түүнээс дээш настай сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бичиг үсгийн мэдлэг, боловсролын түвшин (бэрхшээлийн хэлбэрээр)¹²

Бэрхшээлийн хэлбэр	Боловсролын түвшин						15, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо	
	Бичиг үсгийн боловсролгүй	Бичиг үсгийн боловсролтой	Бага	Бүрэн бус АУНА	Бүрэн АУНА	Мэргэжлийн болон техникийн		Дээд
Хүнд сэтгэцийн эмгэг	38,4	6,4	17,8	22,2	9,2	3,6	2,5	1682
Хөнгөн сэтгэцийн эмгэг	18,4	7,9	24,9	29,9	11,9	4,6	2,3	3187
Оюуны хомсдол-хүнд	65,5	7,7	13,6	8,9	3,3	0,9	0,4	3046
Оюуны хомсдол-хөнгөн	41,2	12,4	25,1	15,7	4,3	0,8	0,6	5061
Тархины гэмтэл-хүнд	10,6	4,2	16,1	35,1	19,1	8,4	6,4	2123
Тархины гэмтэл-хөнгөн	4,9	3,5	19,8	38,4	18,1	9,7	5,1	2765

¹¹ УСГ, “Тахир дутуу иргэдийн нэг удаагийн бүртгэл”, Улаанбаатар, 2004

¹² УСГ, “Тахир дутуу иргэдийн нэг удаагийн бүртгэл”, Улаанбаатар, 2004

Хүснэгт 4. 7-29 насны сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй сургуульд сурагчдын тоо, сургуульд хамрагдалтын хувь (бэрхшээлийн хэлбэр, хүйсээр)¹³

Бэрхшээлийн хэлбэр	Нийт сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд			Сургуульд сурдаг сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд			Сургууль хамрагдалт, хувиар		
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
	Хүнд сэтгэцийн эмгэг	370	313	683	13	13	26	3,5	4,2
Хөнгөн сэтгэцийн эмгэг	579	529	1108	28	67	4,8	4,8	7,4	6,0
Оюуны хомсдол-хүнд	997	840	1837	45	31	76	4,5	3,7	4,1
Оюуны хомсдол-хөнгөн	1335	1210	2545	90	86	176	6,7	7,1	6,9
Тархины гэмтэл-хүнд	565	307	872	36	32	68	6,4	10,4	7,8
Тархины гэмтэл-хөнгөн	587	353	940	71	63	134	12,1	17,8	14,3

¹³ ҮСГ, “Тахир дутуу иргэдийн нэг удаагийн бүртгэл”, Улаанбаатар, 2004

СЭТГЭЦИЙН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДҮҮДИЙН БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХ АСУУДЛЫН ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭ

ОЛОН УЛСЫН БАРИМТ БИЧГҮҮДЭД ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ
ХҮҮХДИЙН ЭРХ ТУСГАГДСАН НЬ

- *НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай Конвенц, 1989¹⁴*
Энэхүү баримт бичигт эсэн мэнд амьдрах эрх, сурч боловсрох, хөгжих эрх, хамгаалуулах эрх, нийгмийн амьдралд оролцох, мэдээлэл хүртэх эрх зэрэг хүүхдийн эдлэх ёстой суурь эрхүүдийг тунхагласан. Тус Конвенцийн 23 дугаар зүйлд тэдэнд тусгай халамж болон тэгш хандах зарчмыг эрхэмлэх тухай тусгасан.
- *НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох тухай Стандарт дүрэм, 1993*
Нийгмийн, улс төрийн амьдралд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс тэгш оролцох нөхцөл боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн засгийн газруудын үйл ажиллагааны хэрэгжилтийг үр дүнтэй болгоход чиглэгдсэн зөвлөмж.
- *Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролын асуудлаарх олон улсын бага хурал*
1994 онд Саламанкад болсон ЮНЕСКО-ийн зохион байгуулсан Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролын асуудлаарх олон улсын бага хурлаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн сургуульд тэгш хамруулан сургахад шаардлагатай бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг улс орнуудад хандан уриалж үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулан гаргасан.

¹⁴ Тус Конвенцид Монгол Улс 1990 онд нэгдсэн

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН АКТУУДАД СЭТГЭЦИЙН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДҮҮДИЙН БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХ ТАЛААР ТУСГАГДСАН БАЙДАЛ

- *Монгол Улсын Үндсэн хууль, 1992*

Үндсэн хуульд хүний амьд явах, эрүүл аюулгүй орчинд амьдрах, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах, сурч боловсрох, эвлэлдэн нэгдэх, халдашгүй чөлөөтэй байх, шашин шүтэх, эс шүтэх, итгэл үнэмшилтэй байх болон бусад эрхүүдийг багтаасан билээ.

- *«Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль», 2005*

2005 онд УИХ «Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль»-ийн шинэчилсэн найруулгыг батлаж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тогтолцооны хүрээнд төрөөс үзүүлж буй үйлчилгээнд хамрагдах боломж, үйлчилгээний цар хүрээнд тодорхой өөрчлөлт оруулсан. Тус хуулинд тусгагдсан үндсэн өөрчлөлтүүдийг дурьдвал:

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тодорхойлох нэр томъёо;
- Нийгмийн халамжийн сангаас үзүүлэх тусламж, хөнгөлөлт;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэн тусгай хэрэгцээт боловсролд үнэ төлбөргүй хамрагдахыг төрөөс дэмжих талаар тусгайлсан заалт;
- Олон нийтийн хэрэгцээний газруудын дэд бүтцийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тусгай хэрэгцээнд нийцүүлэх талаарх зохицуулалт;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний талаарх статистик мэдээллийг цуглуулах, боловсруулах зохицуулалт.

Тус хуулийн долдугаар зүйл нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний сурах, боловсрол эзэмших эрхийг тодруулан зохицуулсан. Сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсрол эзэмших талаарх заалтуудыг тодруулбал:

- 7.1. Сүрьеэ зэрэг архаг халдварт өвчний халдвартай үед байгаагаас бусад тохиолдолд энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэн эрүүл иргэдтэй хамт сурч, боловсрох, мэргэжил эзэмших эрхтэй.
- 7.2. Бүх шатны боловсролын болон мэргэжил олгох байгууллага нь сурч, боловсрох, мэргэжил эзэмших чадвартай энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэнийг энэ хуулийн 7.1-д зааснаас бусад үндэслэлээр элсүүлэхээс, элсэлтийн шалгалтанд оруулахаас татгалзахыг хориглоно.
- 7.3. Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан хүүхэд энэ хуулийн 7.1-д заасан шалтгаангүй бол сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагад эрүүл хүүхэдтэй хамт хүмүүжих эрхтэй.
- 7.5. Тусгай хэрэгцээт боловсрол олгох ясли, цэцэрлэг, бүх шатны сургууль, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд суралцах энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэнийг аймаг, дүүргийн эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комисс тодорхойлно.
- 7.6. Тусгай хэрэгцээт боловсрол олгох сургалтын байгууллага нь энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэний боломжид үндэслэн стандартын дагуу боловсрол эзэмшүүлнэ.
- 7.7. Тусгай хэрэгцээт боловсрол олгох сургалтын стандартыг боловсролын болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран боловсруулж, стандартчиллын төв байгууллагаар батлуулна.

7.8. Тусгай хэрэгцээт боловсрол олгох сургалтын байгууллагын гүйцэтгэх албан тушаалтанд үндсэн цалингийн 10-30 хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдэл хөлс олгоно¹⁵.

7.9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн тусгай хэрэгцээт боловсролд үнэ төлбөргүй.

• ***Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, 2002***

Тус хуулиар хүүхдийн эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг хангах явдлыг төр, гэр бүлийн үндсэн үүрэг байх ёстой тухай заагаад хүүхдийг үндэс угсаа, нийгмийн гарал, байдал, боловсрол, эрүүл мэндийн байдлаар ялгаварлан гадуурхахгүй, эрх тэгш байлгах тухай зарчмыг заасан байна.

• ***Боловсролын тухай хууль, 2002***

Тус хуульд «Монгол Улсын боловсролын зорилго нь бие бялдрын зохих чадавхитай, ..., бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршиж байгаа» бөгөөд «хүмүүнлэг, ардчилсан, тасралтгүй, бүх нийтэд хүртээмжтэй байх» хэмээн хуульчилсан байна.

• ***Бага дунд боловсролын тухай хууль, 2002***

Тус хуульд «...цэцэрлэг, ЕБС-ийн захирлын нийтлэг үүргийг тодорхойлохдоо хамран сургах тойргийнхоо цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх, түр сургалт зохион байгуулах, тэдний эцэг, эх, асран хамгаалагчдад мэргэжлийн туслалцаа үзүүлэх үүрэгтэй» гэсэн байна.

Мөн тус хуулийн 3 дугаар бүлэгт «Ерөнхий боловсролын тусгай сургууль нь тусгай хэрэгцээт боловсрол эзэмших хүүхдэд хөнгөрүүлсэн хөтөлбөр, арга, хэлбэрээр бага, суурь, бүрэн дунд боловсрол, мэргэжил эзэмшүүлэх сургалтын байгууллага гээд оюун ухааны хөгжил дутуу, хэл, хараа, сонсголын эрхтний согогтой хүүхдэд олгох боловсролыг тусгай хэрэгцээт боловсрол гэнэ» гэж заажээ.

¹⁵ Энэхүү заалт нь зөвхөн тусгай хэрэгцээт боловсрол олгодог боловсролын байгууллагуудын ажилтан нарт хамаарч байгаа бөгөөд ердийн сургуультай боловсролын байгууллагад суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллаж буй багш, сурган хүмүүжүүлэгчийн нэмэгдэл хөлсийг зохицуулаагүй орхигдуулсан.

Тус хуулийн 3 дугаар бүлэгт «Ерөнхий боловсролын сургуульд тусгай хэрэгцээт боловсрол эзэмших хүүхдэд бага, суурь, бүрэн дунд боловсрол тусгайлан олгох бүлэг нээн хичээллүүлж болно» хэмээн заажээ.

• **«Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургах хөтөлбөр», 2003**

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулан сургах үзэл баримтлалыг хэрэгжүүлэхийн тулд 2003 онд тус хөтөлбөрийг БСШУ-ны, ЭМ-ийн, НХХ-ын сайдуудын хамтарсан тушаалаар батлан гаргасан байна. Уг хөтөлбөрт дараах асуудлыг дэвшүүлсэн:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сургуульд хамрагдалтыг нэмэгдүүлэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг сургах арга зүйг боловсронгуй болгох;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хамруулан сургах нөхцлийг бүрдүүлсэн сургууль, цэцэрлэгийн тоог нэмэгдүүлэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажилладаг багшийн ур чадварыг нэмэгдүүлэх.

• **«Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах Үндэсний хөтөлбөр (2002-2010)», 2002**

Тус хөтөлбөрт нь хүүхдийн эрүүл мэнд, хоол хүнс, хөгжил, боловсрол, нийгмийн оролцоо, эрхийн хамгаалал, амьдралын орчин зэрэг олон талт асуудлыг хамарсан, нийгмийн суурь үйлчилгээг оновчтой хүргэх бодлого, үйл ажиллагааны чухал баримт бичиг хэмээн тодорхойлсон байна. Энэхүү хөтөлбөрийн нэг заалтад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд эцэг эх, хамт олон гэр бүлд түшиглэсэн нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх тухай дурьджээ. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ерөнхий болон мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх боломжийг өргөжүүлэх, насанд хүрсний дараа тэдний амьдралын баталгааг хангах асуудлыг судалж шийдвэрлэх талаар мөн заасан байна.

СЭТГЭЦИЙН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХЭД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛС

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ, АШИГЛАЖ БУЙ
АРГАЧЛАЛААС ҮҮДЭЛТЭЙ ХЯЗГААРЛАЛТ

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бэрхшээлийг тодорхойлох аргачлал

«Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай» хуулийн аравдугаар зүйлийн нэгд «Иргэн хөгжлийн бэрхшээлтэй болохыг нь түүний оршин суугаа аймаг, дүүргийн эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комисс тогтооно» гэсэн боловч «Нийгмийн даатгалын тухай» хуулийн дагуу үйл ажиллагаагаа явуулж иргэдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тодорхойлдог эрх бүхий байгууллага болох аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс «ердийн өвчин, ахуйн болон үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас даатгуулагчийн¹⁶ хөдөлмөрийн чадвар алдалт, түүний хувь хэмжээ, хугацааг тогтоодог»¹⁷ байна. 16 нас хүрээгүй иргэн нийгмийн даатгалын тогтолцооны «даатгуулагч» байх боломж нь хязгаарлагдмал¹⁸ тул Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс 16 нас хүрээгүй иргэдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоодоггүй байна.

¹⁶ “Даатгуулагч” гэж хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ”, “Нийгмийн даатгалын тухай хууль”, 2-р зүйл

¹⁷ УИХ, “Нийгмийн даатгалын тухай хууль”, 1994 оны 5-р сарын 31-ний өдөр

¹⁸ Хөдөлмөрийн хуульд 14 нас хүрсэн хүүхэд тодорхой нөхцөлтэйгээр хөдөлмөр эрхлэхийг зөвшөөрдөг.

Тус комисс нь «Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм»-д¹⁹ тусган заасны дагуу 16 нас хүрсэн иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох үүрэгтэй байна.

Одоогийн байдлаар 16 нас хүрээгүй иргэдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тухайн хүүхдийн оршин суугаа аймаг, дүүргийн Эрүүл мэндийн нэгдэл/Эрүүл мэндийн төвийн Эмчилгээний чанарын хяналтын комисс²⁰ шийдвэр гарган тогтоодог²¹ тогтолцоо үйлчилж байгаа боловч «Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль»-д заасны дагуу зөвхөн аймаг, дүүргийн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс иргэний бэрхшээлтэй эсэх, бэрхшээлийн төрөл, түвшнийг тогтоох эрхтэй байдаг тул Эмчилгээний чанарын хяналтын комиссын шийдвэр нь эрх зүйн чадамжгүй юм.

Дээрх эрх зүйн актуудыг үзэхэд 16 нас хүрээгүй хүүхдүүдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийн талаарх шийдвэр гаргах эрх зүйн зохицуулалт нь дотоод зөрчилдөөнтэй нь харагдаж байна. Энэхүү зөрчилдөөн нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн бэрхшээлтэй эсэх, тэдний бэрхшээлийн хэлбэр, боловсрол эзэмших чадварын хязгаарлалтыг нарийвчлан тогтоох, хүүхэд «Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль»-д заасан тусламж, тэтгэлэг болон бусад үйлчилгээ авах, боловсрол эзэмших боломжийг хязгаарлаж байгаа юм.

¹⁹ Засгийн газрын 1994 оны 171-р тогтоолын хавсралт “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм”

²⁰ Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс нь Эрүүл мэндийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2005 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 135/62 тоот тушаалын нэгдүгээр хавсралт “Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа хөдөлмөрийн тусгай нөхцөл тогтоох тухай заавар”-ын дагуу бэрхшээлийн хэлбэр, байдал, хөдөлмөр алдалтын хувийг тогтоодог

²¹ Улаанбаатар хотод сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх магадлалыг Сэтгэцийн эмнэлэг, Наркологийн төвийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс үйлддэг байна.

БОЛОВСРОЛЫН ТОГТОЛЦООТОЙ ХОЛБОГДОЛТОЙ ХҮЧИН ЗҮЙЛС

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол эзэмшүүлэх тогтолцооны хөгжил

Монгол Улсын боловсролын тогтолцоо нь сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд үндсэн хоёр чиглэлээр (ердийн сургалттай ерөнхий боловсролын сургуульд бусад хүүхдүүдийн хамт; тусгай сургалттай ерөнхий боловсролын сургуульд) боловсрол эзэмших боломжийг олгодог.


1990 оноос өмнө хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг бусад хүүхдүүдээс тусгаарлан тусгай сургалттай сургуульд боловсрол эзэмшүүлэх бодлого голчилж байсан бөгөөд тус бодлогын хүрээнд 1964 онд хараа, сонсголын согогтой хүүхдийг боловсролд хамруулах үүднээс тусгай сургалттай 29-р сургууль байгуулагдсан нь тусгай хэрэгцээт боловсролын тогтолцооны эхлэл болсон. 1967 онд тусгай сургалттай 25-р сургууль байгуулагдсан нь оюун ухааны бэрхшээлтэй хүүхдүүдийг тэдэнд зориулагдсан хөтөлбөрөөр боловсролын үйлчилгээнд хамруулах нөхцөл боломжийг бүрдүүлэх анхны алхам болсон. Одоогоор Улаанбаатар хотод²² сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд ерөнхий боловсрол олгодог нийт дөрвөн тусгай сургалттай ЕБС үйл ажиллагаагаа явуулж байгаа ба тус сургуулиудад 2006 оны 4-р сарын байдлаар нийт 1100 орчим сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд²³ тусгай сургалтын хөтөлбөрийн дагуу боловсрол эзэмшиж байна.²⁴

1990-ээд оноос эхлэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг нийгэмд тэгш хамруулах, тэднийг нийгэмшүүлэх байр сууринаас тэднийг ердийн сургалттай сургуульд бусад хүүхдүүдийн хамт боловсрол эзэмшүүлэх бодлого голчлох болсон.

²² Хөдөө орон нутагт сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тусгай хэрэгцээнд нийцсэн тусгай сургалттай ЕБС үйл ажиллагаагаа одоогоор явуулаагүй байна

²³ Сургуулиудын нийт багтаамж 1 000-1 050 хүүхэд

²⁴ Энэхүү судалгаанд хамрагдсан сургуулийн насны хүүхдүүдийн 10 % нь Улаанбаатар хотод байрлах тусгай сургалттай ЕБС-иудад суралцаж байлаа.



Зураг 1. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн боловсрол эзэмшиж буй байдал

Ердийн сургалттай ЕБС-д сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцахад тулгардаг хүндрэл, бэрхшээл

Сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ердийн сургалттай ЕБС-д бусад хүүхдийн хамт ердийн сургалтын хөтөлбөрийн²⁵ дагуу суралцахад хүүхдийн бэрхшээл (хүүхдийн эрүүл мэндээс шалтгаалсан суралцах чадварын хязгаарлалт) нь тус хүүхэд суралцах боломжийг хязгаарлах гол хүчин зүйл болдог байна.


Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг ердийн сургалттай сургуульд хамруулан сургах бодлогыг дэмжих зорилгоор ЕБС, цэцэрлэгийн үйл ажиллагаанд үнэлгээ дүгнэлт өгөхдөө тухайн сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж буй байдлыг ЕБС-ийн үйл ажиллагаанд үнэлгээ хийх үзүүлэлтүүдийн нэг болгосон²⁶ боловч ердийн сургалттай ЕБС-д суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувьсах зардал болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй тулж ажиллаж

²⁵ Ердийн сургалттай ЕБС-д суралцаж буй хүүхдүүдийн 36 % -д энэхүү бэрхшээл тогтмол тулгардаг байсан.

²⁶ 2003 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн БСШУЯ-ны сайдын 321-р тушаал

буй багш, сурган хүмүүжүүлэгчийн цалин нэмэгддэггүй²⁷ нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ердийн сургалттай ЕБС-д боловсрол эзэмшихэд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг агуулж байгаа юм.

Нөгөөтэйгүүр аймаг, сумын ЕБС-ийн багш, сурган хүмүүжүүлэгч нарын дунд сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллах мэдлэг, чадвартай, дадлагатай боловсон хүчин төдийлэн байхгүй нь хөдөө орон нутагт ердийн сургалттай ЕБС-д суралцаж буй/цаашид суралцах хүүхдүүдийн боловсрол эзэмших боломж, эзэмшиж буй боловсролын чанарыг хязгаарлаж байна.



Зураг 2. Судалгаанд хамрагдсан ердийн сургалттай ЕБС-д сурч байгаад сургууль завсардсан хүүхдийн завсардсан шалтгаан

²⁷ Тэдний хувьд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль”-д заасан нэмэгдэл хөлс олгох зохицуулалт үйлчилдэггүй

Тусгай сургалттай ЕБС-д сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцахад тулгардаг хүндрэл, бэрхшээл

Хөдөө орон нутагт сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулагдсан тусгай сургалттай ЕБС, ердийн сургалттай ЕБС-д тусгай сургалттай анги байдаггүй нь тусгай сургалттай сургуульд суралцах зайлшгүй шаардлагатай (ердийн сургалттай ЕБС-ийн сургалтын хөтөлбөрөөр суралцах боломжгүй) бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсрол эзэмших, нийгэмших боломжийг хязгаарлаж байна²⁸.

Үүний зэрэгцээ Улаанбаатар хотод байрлах тусгай сургалттай сургуулиудад сурагчдын дотуур байр байдаггүй нь хөдөө орон нутгаас ирсэн хүүхдүүд тус сургуулиудад суралцах боломжийг хязгаарлаж байгаа юм.

Мөн сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах мэргэшсэн мэргэжилтэн, багш боловсролын салбарт дутагдалтай байгааг онцлон дурьдах шаардлагатай²⁹.

Тусгай сургалттай ЕБС-д суралцаж буй хүүхдүүд сургуулиасаа завсардах магадлал харьцангуй бага байдаг бөгөөд тус сургуульд элссэн, өөр сургуулиас шилжиж ирсэн хүүхдүүд ихэнх тохиолдолд сургуулиа дүүргэдэг байна. Тусгай сургалттай ЕБС-иас сургууль завсардаж буй хүүхдүүдийн завсардсан шалтгаан нь тэдний эрүүл мэндийн байдал дордож цаашид үргэлжлүүлэн суралцах боломжгүй болсонтой холбоотой байдаг байна.

²⁸ Судалгаанд хамрагдсан сургуулийн насны хүүхдийн 39 % нь сургуульд огт суралцаагүй байв.

²⁹ 1990 оноос өмнө Унгар, ЗХУ зэрэг орнуудад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллахаар мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэж байсан боловч 1990 оноос хойш шинээр бэлтгэгдэх боловсон хүчний тоо эрс цөөрсөн нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй зохих түвшинд ажиллах чадвар, мэдлэгтэй багш, сурган хүмүүжүүлэгч боловсролын салбарт дутагдах болсон.

Сургуулийн өмнөх боловсрол эзэмшихэд тулгардаг хүндрэл, бэрхшээл

Хүүхдийг, ялангуяа сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ЕБС-д суралцаж эхлэхээс нь өмнө сургуулийн өмнөх боловсролд хамруулах, нийгэмшүүлэх нь хүүхдийн хөгжил, суралцах дадлагатай болоход онцгой байр суурь эзэлдэг.

2006 оны хаврын байдлаар сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан тусгай сургалттай сургуулийн өмнөх боловсрол олгодог мэргэжлийн боловсон хүчинтэй, тусгайлсан сургалтын хөтөлбөртэй байгууллага Улаанбаатар хот болон хөдөө орон нутагт байдаггүй. Сувиллын цэцэрлэг яслийн 10-р цогцолбор³⁰ саажилттай³¹ хүүхдүүдэд сургуулийн өмнөх боловсрол олгох, тэднийг сувилах үйл ажиллагаа явуулдаг байна.

Хэдийгээр тус цогцолборын үйл ажиллагааны үндсэн чиглэл нь сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд сургуулийн өмнөх боловсрол олгоход чиглэгдээгүй боловч саажилтын нэг үр дагавар нь олонтаа хүүхдийн сэтгэцэд нөлөөлдөг тул тус байгууллагыг сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд сургуулийн өмнөх боловсрол олгодог ганц байгууллага гэж үзэж болох юм.

Байнгын асаргаа шаардах хүүхдийн эцэг эхэд Нийгмийн халамжийн сангаас 18000 төгрөгийн байнгын асаргааны тэтгэмжийг зөвхөн тухайн өрхийн амьжиргааны түвшин нэн ядуу бол олгодог байна. Сувиллын цэцэрлэг, яслийн 10-р цогцолборын судалгаагаар тархины саажилттай хүүхдийн асаргаа, нөхөн сэргээлтэд сард дунджаар 98000 төгрөгийн нэмэлт хэрэглээ шаардлагатай гэж тодорхойлжээ.

***«Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийн байдал»,
Судалгааны тайлан***

³⁰ Тус цогцолбор нь 120 хүүхдийн багтаамжтай бөгөөд 2006 оны 4-р сарын байдлаар 100 орчим (хүүхдийн тоо хэлбэлзэлтэй байдаг, нийт хүүхдүүдийн 70 орчим хувь нь Улаанбаатар хотын харьяат) хүүхдийг сувилж байна.

³¹ Infantile cerebral paralysis

ЭЦЭГ ЭХЭЭС ШАЛТГААЛАХ ХҮЧИН ЗҮЙЛС


Эцэг эхийн хандлага

Сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуульд сурч боловсрол эзэмшиж буй байдалд хүүхдийн эцэг эхийн хүүхдийнхээ боловсроход хандах хандлага, боловсролд хамруулах боломжийн талаарх мэдлэг шууд нөлөөлдөг байна. Эцэг эхчүүд (асран хамгаалагч нар) төрийн зүгээс ямар нэгэн дэмжлэг, тусламж шаардаж болох талаар мэдээлэл хомс нь тэдний энэхүү идэвхи гаргаагүйд тодорхой хэмжээгээр нөлөөлсөн байх боломжтой.

Өрхийн амьжиргаа, эцэг эхийн боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн байдал

Хүүхдийн өрхийн амьжиргааны болон орлогын түвшин тухайн өрхөд өсч, хүмүүжиж буй хүүхдийн боловсрол эзэмшиж буй байдал, ялангуяа хүүхдийн эзэмшиж буй боловсролын чанарт тодорхой хэмжээгээр нөлөөлдөг нь гарцаагүй боловч сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд тухайн хүүхдийн өрхийн санхүүгийн байдал, өрхийн орлогын түвшин, өрхийн насанд хүрсэн гишүүдийн хөдөлмөр эрхлэлт зэрэг тухайн өрхийн нийгэм эдийн засгийн үзүүлэлтүүд хүүхдийн эмчилгээ, оношлогоонд зарцуулах хөрөнгө, мөнгө, эцэг эхийн идэвхийг хязгаарладаг боловч хүүхдийн боловсрол эзэмшиж буй байдалд шууд нөлөөлдөггүй байна.

Эцэг эхийн боловсролын түвшин хүүхдийн боловсрол эзэмшиж буй байдалд тухайн хүүхдийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран нөлөөлдөг хүчин зүйл боловч энэхүү нөлөө нь бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд илүү илэрдэг байж болзошгүй юм. Энэхүү уяалдаа холбоо нь тус судалгааны явцад дараах байдлаар илэрч байв: хүүхдийн эцэг эхийн боловсролын түвшин дээшлэхийн зэрэгцээ тэдний өөрийн хүүхдийн боловсрол эзэмшиж буй байдалд тавих анхаарал нэмэгддэг, тэдний хүүхэддээ боловсрол эзэмшүүлэх, бэрхшээлийг оношлох, халамжийн үйлчилгээнд хамрагдах талаар авч буй арга хэмжээ нь илүү үр дүнтэй болдог байна.



Зураг 3. Судалгаанд хамрагдсан хүүхдийн боловсрол эзэмшиж буй байдал (эцэг/эхийн боловсролын түвшин/ хүүхэд боловсролын үйлчилгээнд хамрагдсан байдалтай харьцуулахад)


ЭРҮҮЛ МЭНДИЙН ТОГТОЛЦООНООС ХАМААРАХ ХҮЧИН ЗҮЙЛС

Сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн оношлогоо үнэн зөв, цаг хугацаандаа хийгдэж, шаардагдах эмчилгээ, нөхөн сэргээх үйл ажиллагаа хийгдэх нь тухайн хүүхдийн боловсрол эзэмших нөхцөл боломжийг бүрдүүлэхэд нөлөөлдөг гол хүчин зүйлийн нэг юм.

Сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн бэрхшээлийн оношлогоог хөдөө орон нутагт аймгийн Нэгдсэн эмнэлэгт нарийн мэргэжлийн эмч нарын оролцоог тэр болгон хангахгүйгээр хийж байгаа нь хүүхдийн бэрхшээлийн оношлогоо, эмчилгээ, нөхөн сэргээлт шаардагдах түвшинд хийгдэхгүй байгаад нөлөөлж байна. Ийнхүү оношлогоо, эмчилгээ зохих түвшинд, цаг хугацаанд хийгдэхгүй нь эцсийн байдлаар хүүхдийн боловсрол эзэмшиж буй байдалд сөргөөр нөлөөлж байгаа юм.

Нийслэлээс 1000 ба түүнээс дээш км газарт амьдардаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг Нийслэлд ирж эмчлүүлэхэд нэг талын унааны зардлыг Нийгмийн халамжийн сангаас олгохоор заасан байдаг. Улсын нийгмийн халамжийн газрын (хуучин нэрээр) мэдээгээр 2003 онд нийтдээ 885 хүүхэд энэ тусламжийг авчээ.

Улсын нийгмийн халамжийн газрын мэдээнээс



Зураг 4. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн оношлогоо хийлгэсэн эмнэлэг

Судалгаанд хамрагдсан сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн 66 % нь нэг удаа, 8 % нь хоёр удаа, 17 % нь гурав болон түүнээс олон удаа эмнэлгийн байгууллагад оношлогоо хийлгэсэн байхад хүүхдүүдийн 9 % нь ямар нэгэн байдлаар оношлогоо огт хийлгээгүй байлаа³². Хүүхдийн бэрхшээлийн оношлогоо хийлгэх, эмчилгээний удирдамж, зөвлөгөө эрүүл мэндийн байгууллагаас авах давтамжид өрхийн байршил³³, амьжиргааны түвшин, эцэг эхийн хандлага, идэвхи зэрэг хүчин зүйл шууд болон шууд бус байдлаар нөлөөлдөг байна.

³² Тухайн хүүхдүүдийн хувьд бэрхшээл нь бага насанд нь илэрсэн тул тэдний эцэг эх нь нарийн мэргэжлийн эмчид хандаагүй байх боломжтой

³³ Хөдөө орон нутгийн хувьд сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд нь сумын эмчийн хяналтанд байдаг ч сумын эмчийн мэргэжлийн ур чадвар, мэдлэг нь сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эмчлэх, шаардагдах заавар, зөвлөгөө өгөх нөхцөл боломжийг олгодоггүй (сумын эмч нь гол төлөв дотрын эсвэл хүүхдийн эмч байдаг)

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТОГТОЛЦООНООС ХАМААРАХ ХҮЧИН ЗҮЙЛС

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, хүүхдийн өрх нийгмийн хамгааллын тогтолцооны хүрээнд тусламж, дэмжлэг, үйлчилгээ авах эрх үүссэн эсэх нь тухайн хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэйгээс гадна өрхийн амьжиргааны түвшингээс (хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нь зөвхөн нэн ядуу амьдралтай өрхөд амьдардаг байвал хөнгөлөлт, тусламж авах эрх үүсдэг) хамааралтай байдаг³⁴. Энэхүү зохицуулалт нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол эзэмшихэд шууд бус байдлаар сөргөөр нөлөөлөх эрсдлийг агуулж байгаа юм.

Сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд Нийгмийн халамжийн сангаас тусгай сургалттай сургуульд суралцдаг харах, сонсох, ярих боломж нь хязгаарлагдмал сурагч, түүний эцэг эх, асран хамгаалагчийн тусгай сургалттай сургуульд ирж, очих унааны зардлыг жилд нэг удаа хөнгөлдөг боловч хуулийн энэхүү заалт нь сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд үйлчилдэггүй³⁵ нь нөхцөл байдлыг улам даамжруулж байна.

³⁴ “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай” хуулийн 5-р зүйл

³⁵ “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай” хуулийн 5-р зүйлийн 1-ийн 5-р заалт

ДҮГНЭЛТ

Энэхүү судалгааны явцад цуглуулсан мэдээлэлдээ дүн шинжилгээ хийсний эцэст дараах дүгнэлтүүдийг хийсэн болно:

- Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг тодорхойлох аргачлал тодорхой бус байгаа байдал нь НХХЯ, БСШУЯ, ЭМЯ, ҮСГ-ын сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн талаарх тоон мэдээлэл зөрүүтэй байна;
- Монгол Улс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх тусгагдсан олон улсын баримт бичгүүдийг соёрхон баталж хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн суурь эрхийн нэг болох сурч боловсрох эрхээ эдлэх эрх зүйн орчинг бүрдүүлсэн байна;
- Сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсроход дараах хүчин зүйлс нөлөөлж байна:
 - «Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль», «Нийгмийн даатгалын тухай хууль»-ийн холбогдох заалтуудын зөрчилдөөний улмаас 16 нас хүрээгүй хүүхдүүдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг эрх зүйн чадамжтайгаар тодорхойлох тогтолцоо бүрдээгүй байна;
 - Ердийн сургалттай ЕБС-д суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувьсах зардал, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй багш, сурган хүмүүжүүлэгчийн цалин нэмэгддэггүй байна;

- Ердийн сургалттай ЕБС-ийн багш, сурган хүмүүжүүлэгч нарын сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллах мэдлэг, дадлага хангалтгүй байна;
- Хөдөө орон нутагт сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулагдсан тусгай сургалттай ЕБС, ердийн сургалттай ЕБС-д тусгай сургалттай анги байдаггүй нь тусгай сургалттай сургуульд суралцах зайлшгүй шаардлагатай бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсрол эзэмших, нийгэмших боломжийг хязгаарлаж байна;
- Сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тусгай хэрэгцээнд нийцсэн сургуулийн өмнөх боловсрол олгодог боловсролын байгууллага байхгүй байна;
- Нийгмийн хамгааллын тогтолцооны хүрээнд авч болох дэмжлэг, тусламжийн талаарх хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхийн мэдлэг хангалтгүй байна;
- Сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн оношлогоо, эмчилгээ зохих түвшинд, цаг хугацаанд хийгдэхгүй байна. Энэхүү байдал нь хөдөө орон нутагт илүүтэй илэрдэг байна.

ЗӨВЛӨМЖ

Сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсрол эзэмших нөхцөл боломжийг дээшлүүлж тэдэнд боловсрол эзэмших таатай орчныг бүрдүүлэхэд бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгч нар дараах зарчмыг баримтлах нь оновчтой байх болно. Үүнд:

- Хүүхэд болгон бэрхшээлийн түвшингөөс үл харгалзан өөрийн боломжид тохирсон байдлаар сурах, боловсрол эзэмших эрхтэй;
- Хүүхэд болгон нийгмийн амьдралд идэвхитэй оролцох, нийгэмших эрхтэй;
- Хүүхдэд эрхээ эдлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх нь тэдний эцэг эх, нийгэм, төрийн шууд үүрэг байна.

Сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн бэрхшээлийн тодорхойлолтыг чанартай, цаг хугацаанд хийж хүүхдийн боловсрол эзэмших нөхцлийг бүрдүүлэхийн тулд «Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль» болон бусад холбогдох эрх зүйн актуудад дараах өөрчлөлтийг оруулж болох юм:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бэрхшээлийн хэлбэр, түвшин, тухайн хүүхдийн боловсрол эзэмших сургуулийн хэлбэрийг³⁶ тодруулах эрх бүхий байгууллагыг шинээр байгуулж эсвэл одоо үйл ажиллагаа явуулж буй Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагааны цар хүрээнд

³⁶ Суралцах чадварыг дараах байдлаар ангилж болох юм: ердийн сургалттай ЕБС-ийн ердийн ангид; тусгай сургалттай ЕБС-д; суралцах чадваргүй.

өөрчлөлт оруулан хүүхдийн бэрхшээлтэй эсэхийг магадлах байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн орчинг бүрдүүлэх шаардлагатай. Энэхүү асуудлыг дараах байдлаар шийдвэрлэж болох юм:

- Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын ажил үүргийн хуваарьт нэмэлт өөрчлөлт оруулан тэд хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэх, бэрхшээлийн хэлбэр, боловсрол эзэмших боломжийн талаар шийдвэр гаргадаг болох;

эсвэл:

- Аймаг, дүүргийн Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн дэргэд «Эмнэлэг боловсролын магадлах комисс»-ийг Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын жишгээр шинээр байгуулах. Тус комисс нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бэрхшээлтэй эсэх, бэрхшээлийн хэлбэр, боловсрол эзэмших чадварыг тогтоох³⁷ үүргийг хүлээх.

Сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн суурь боловсрол эзэмших бодит боломжийг нэмэгдүүлэх, тэдний боловсролын үйлчилгээнд хамрагдах нөхцөл боломжийг сайжруулах чиглэлээр Боловсролын багц хууль болон бусад холбогдох эрх зүйн актуудад дараах өөрчлөлт, нэмэлтүүдийг оруулах саналуудыг дэвшүүлж байна:

- Сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн суурь боловсрол эзэмших нөхцөл боломжийг дээшлүүлэхийн тулд 1990-ээд оноос хойш баримталсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг ердийн сургалттай ЕБС-д бусад хүүхдийн хамт интегралчлан сургаж, тусгай сургалттай сургуулийн тогтолцоог халах бодлогоос татгалзаж тусгай боловсролын тогтолцоо, ердийн сургалттай ЕБС-д бусад хүүхдийн хамт суралцуулах тогтолцоог уялдаа холбоотойгоор хөгжүүлэх шаардлагатай. Ингэснээр сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд өөрийн

³⁷ Тус комиссын шийдвэрээр бэрхшээлтэй нь тогтоогдсон хүүхэд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль”-ийн дагуу бэрхшээлтэй иргэний эдэлдэг давуу эрхийг эдлэх эрх зүйн орчин бүрдэх шаардлагатай тул дээрх хуулинд өөрчлөлт оруулах шаардлагатай

эрүүл мэндийн байдал, боловсрол эзэмших чадвартаа тохирох байдлаар ердийн болон тусгай сургалттай ЕБС-д боловсрол эзэмших боломж нь нэмэгдэх болно;

- Эрх бүхий байгууллагын тодорхойлсноор ердийн ЕБС-д суурь боловсрол эзэмших чадвартай хүүхдүүд өөрийн оршин сууж буй орон нутгийн ЕБС-д суралцаж суурь боловсрол эзэмших боломжийг нэмэгдүүлэхийн тулд:
 - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн суралцахад зориулагдсан хувьсах зардлыг³⁸ нэмэх;
 - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй багшийн ажлын үнэлгээ гаргахад сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурлагын амжилтыг тооцохгүй байх зохицуулалт хийх;
 - Сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурлагын амжилтын үнэлгээг тухайн хүүхдийн нийгэмшиж буй байдал, ахиц гарч буй байдал дээр тулгуурлан хийх тогтолцоог боловсруулан ашиглах;
- Эрх бүхий байгууллагын тодорхойлсноор суурь боловсрол тусгай сургалттай ЕБС-д эзэмших боломжтой хүүхдүүдэд суурь боловсролыг дараах байдлаар олгож болно:
 - Аймгийн төвүүдэд ердийн сургалттай ЕБС-д сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан тусгай анги нээн боловсрол олгох³⁹;

³⁸ Эрх бүхий байгууллагын дүгнэлтээр бэрхшээлтэй нь тогтоогдсон хүүхдийн хувьсах зардал нь бусад хүүхдийн хувьсах зардлаас өндөр байх шаардлагатай. Европын холбооны орнуудад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургалтын хувьсах зардлыг 2,5-3 дахин өндрөөр тооцдог жишгийг ашиглаж болох юм.

³⁹ Тусгай ангид суралцаж буй хүүхдүүдэд албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрийн загварыг ашиглаж болох юм. Тусгай ангид суралцаж буй хүүхдийн сургалтын хувьсах зардлыг тусгайлан тооцоолж тогтоох, хүүхдийн дотуур байр, хүүхдүүд өрх бүсийн төвд оршин суудаггүй тохиолдолд сурагч, эцэг эх, асран хамгаалагчийн унааны зардал зэрэг асуудлуудыг цогц байдлаар шийдвэрлэх шаардлагатай.

- Ердийн болон тусгай сургалттай ЕБС-д суралцах боломжгүй хүүхдүүдийг боловсролын үйлчилгээнд хамруулах, тэднийг нийгэмшүүлэхийн тулд гэрээр боловсрол эзэмшүүлэх тогтолцоог боловсруулан хэрэгжүүлэх: хүүхдийн оршин сууж буй орон нутгийн ЕБС-ийн сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах талаар мэргэшсэн багш хүүхдийн гэрт нь очиж тусгай хөтөлбөрийн дагуу хүүхдэд боловсрол олгох үйлчилгээг үзүүлэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй харьцаж буй ердийн болон тусгай сургалттай ЕБС-уудын багш, сурган хүмүүжүүлэгч нарын мэргэжлийн чадвар⁴⁰, мэдлэгийг нэмэгдүүлэх шаардлагатай.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн нийгмийн хамгааллын тогтолцооны хүрээнд эдэлж буй үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд нийгмийн хамгааллын багц хуулинд дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулж болох юм:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон тухайн хүүхдийн өрхийн амьжиргааны түвшин хүүхэд/өрх, төрийн халамжийн тогтолцооны хүрээнд халамжийн үйлчилгээ авах/эс авахад нөлөөлж буй тогтолцоог өөрчилж⁴¹, хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй байдал нь нийгмийн халамжийн тогтолцооны хүрээнд хөнгөлөлт авах эрх үүсэхэд хангалттай нөхцөл болсон тогтолцоонд шилжих.

Бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эх, олон нийт, төрийн түшмэл, эрүүл мэндийн болон боловсролын байгууллагын ажилтнуудын ойлголт дээшлүүлэх, иргэдийн хандлагад өөрчлөлт оруулахын тулд:

- Сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд бусдын адил суралцах, боловсрол эзэмших, нийгмийн амьдрал идэвхитэй оролцох бүрэн эрхтэй бөгөөд тэдэнд тус эрхээ бүрэн хэмжээгээр эдлэх нөхцөл боломжийг олгох нь

⁴⁰ Боловсролын чиглэлийн мэргэжлээр боловсон хүчин бэлтгэдэг их, дээд сургуулиудын хичээлийн хөтөлбөрт сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол эзэмшүүлэх онцлогийг тусгах нь оновчтой байх болно.

⁴¹ Нийгмийн халамжийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулинд өөрчлөлт оруулах

ардчилсан нийгэм, төрийн үндсэн үүргийн нэг гэдгийн олон нийт, төрийн бүх төвшний түшмэлүүдэд сурталчилж ойлголтыг⁴² нь өөрчлөх;

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эх, асран хамгаалагч нарт төрөөс үзүүлж буй халамжийн, эрүүл мэндийн боловсролын үйлчилгээний цар хүрээ, үйлчилгээ авах нөхцөл, үйлчилгээ авах боломжийн талаар мэдээлэл хүргэж тэдний өөрийн хүүхдийн боловсрол эзэмших, нийгэмшихэд оролцох оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай.

⁴² Олонхи тохиолдолд иргэд мэдээлэл дутмаг, асуудлын талаар үнэн зөв мэдээлэлгүй байгаа нь тэдний хандах хандлага таагүй байдагт нөлөөлдөг

ЭХ СУРВАЛЖУУД

- УИХ, «Боловсролын тухай хууль», 2002
- УИХ, «Нийгмийн халамжийн тухай хууль», 1998, 2005
- УИХ, «Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль», 2005
- УИХ, «Тахир дутуу иргэдийн нийгмийн халамжийн тухай хууль», 1995
- УИХ, «Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хууль», 2002
- УИХ, «Нийгмийн даатгалын тухай хууль», 1994
- Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар, «Нийгмийн даатгалын холбогдолтой эрх зүйн актын эмхтгэл», 2005
- ҮСГ, «Тахир дутуу иргэдийн нэг удаагийн бүртгэл», 2004
- «МЭ КОНСАЛТИНГ», «Тахир дутуу иргэдийн хөдөлмөрийн зах зээл дээрх оролцоо», Судалгааны тайлан, 2004
- «МЭ КОНСАЛТИНГ», «Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн байдлын судалгаа», Судалгааны тайлан, 2003
- Эрүүл мэндийн тусламжийг удирдах газар, «Эрүүл мэндийн үзүүлэлтүүд», 2004

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхийн холбоо, «Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийн байдал», Судалгааны тайлан, Улаанбаатар, 2005
- Ministerstva školství, mládeže a tělovýchovy České republiky, Směrnice Ministerstva školství, mládeže a tělovýchovy k integraci dětí a žáků se speciálními vzdělávacími potřebami do škol a školských zařízení č.j.: 13 710/2001-24 ze dne 6.6.2002. Praha, 2002
- Tungalag Johnston, «The Status of Training and Employment Policies and Practices for People with Disabilities in Mongolia», ILO, 2002
- Нийгмийн салбарыг хөгжүүлэх төв, «Хуулин дахь тахир дутуу хүний тодорхойлолтыг боловсронгуй болгох нь», Улаанбаатар, 2004



НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

**«СЭТГЭЦИЙН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДҮҮДИЙН
СУУРЬ БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХ БОЛОМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ
ЧИГЛЭЛИЙН БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ»**

ХЭВЛЭЛИЙН ХУУДАС: 5.4

ХЭВЛЭСЭН ТОО: 500 ш

«СОДПРЕСС» ХХК-д ХЭВЛЭВ.

**УЛААНБААТАР ХОТ
2006 ОН**